

2024 он 04 сар 19 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

### Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох тухай

Говь ХК-ийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь хэсгийг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн 2023 оны тусдаа /охин компаниуд ороогүй/ санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Их Монгол Хөлөг Аудит” ХХК-ийг сонгосугай.
2. “Их Монгол Хөлөг Аудит” ХХК-тай байгуулах гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д зөвшөөрсүгэй.
3. Хөндлөнгийн аудитын дүгнэлт, захидлыг хүлээн авч, Эрсдэл аудитын хороо болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д үүрэг болгосугай.
4. “Их Монгол Хөлөг Аудит” ХХК-тай байгуулах гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/, Санхүү бүртгэл хариуцсан захирал /Д.Содгэрэл/ нарт тус тус үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



Д.ГЭРЭЛМАА